



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 26 өдөр

Дугаар A/203

Ховд

Ажлын хэсэг байгуулж, удирдамж батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "А" заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газраас холбогдох байгууллагуудтай хамтран сумдад "Нээлттэй хаалганы өдөр" арга хэмжээг зохион байгуулан "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил" болон "Хариуцлагатай тунгалаг төр" хөтөлбөрийн нээлт хийж, байгууллага бүр үндсэн чиг үүргийн дагуу иргэдэд мэдээлэл өгч, иргэдийн санал, гомдол, эрэлт хүсэлтийг хүлээн авч, зарим төрийн үйлчилгээг газар дээр нь шуурхай хүргэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Сумдад төрийн үйлчилгээг чанартай хүргэж, иргэдийн эрэлт хүсэлтийг хууль, тогтоомжийн хүрээнд шуурхай шийдвэрлэж ажиллахыг ажлын хэсэг /Д.Энхболд, Б.Ганболд/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Zax A/203 Ch  
02 00338

Аймгийн Засаг даргын 2019 оны  
03 дугаар сарын 26-ны өдрийн  
A/203 дугаар захирамжийн  
1 дүгээр хавсралт

### АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

1.Ховд, Эрдэнэбүрэн, Буянт, Мянгад, Дөргөн, Чандмань, Мөнххайрхан,  
Дуут сумдад төрийн үйлчилгээ үзүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Энхболд

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүдэд: М.Отгонхишиг

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн  
захиргааны удирдлагын хэлтсийн  
ахлах мэргэжилтэн

Б.Энхбаатар

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн  
захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Д.Батцэнгэл

-Мал эмнэлгийн газрын дарга

Б.Оюунтунгалаг

-Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн  
хэлтсийн дарга

3.Өмirtай

-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын  
газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга

Г.Бат-Өлзий

-Хүнс, хөдөө аж ахуйн Мал үржлийн албаны дарга

М.Батсайхан

-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын  
газрын мэргэжилтэн

Д.Янжиндулам

-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний  
газрын мэргэжилтэн

Н.Бямбахүү

-Хөдөлмөр халамжийн үйлчилгээний  
газрын мэргэжилтэн

Б.Оюунчимэг

-Нийгмийн даатгалын хэлтсийн тэтгэврийн  
байцаагч

А.Туяа

- Улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгч

Н.Мөнхцэцэг

- Улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгч

Т.Өсөхболд

-Прокурорын газрын Хэрэг бүртгэл мөрдөн  
байцаах ажиллагаануудад хяналт тавих  
хяналтын прокурор, хууль цаазын дэд зөвлөх

Ж.Оронбасар

-Цагдаагийн газрын хошууч

2. Алтай, Булган, Үенч, Дарви, Зэрэг, Цэцэг, Мөст, Манхан сумдад төрийн үйлчилгээ үзүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Ганболд

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Гишүүдэд: Т.Алимаа

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Д.Мөнхжагаа

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Б.Баярсүх

-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Ц.Мягмарсүрэн

-Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга

Б.Мөнхбаатар

-Мал эмнэлгийн газрын Мал, амьтан эрүүл мэндийн албаны дарга

Т.Цагаанхишиг

-Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга

М.Батсайхан

-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

Г.Түнжээ

-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтэн

С.Чулуунхүү

-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Мэргэжилтэн

Д.Дэлгэрмаа

-Нийгмийн даатгалын хэлтсийн тэтгэврийн Байцаагч

Ч.Нансалмаа

-Улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгч

С.Отгонзаяа

-Улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгч

А.Анхбаяр

-Прокурорын газрын Хэрэг бүртгэл мөрдөн байцаах ажиллагаануудад хяналт тавих хяналтын прокурор, хууль цаазын дэд зөвлөх

Б.Болормаа

-Цагдаагийн газрын ахмад

Аймгийн Засаг даргын 2019 оны  
03 дугаар сарын 26-ны өдрийн А/203  
дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

УДИРДАМЖ

"Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил"-ийн хүрээнд  
сумдад газар дээр нь төрийн үйлчилгээ үзүүлэх  
ажлын хэсэг ажиллах тухай

Зорилго: Аймгийн Засаг даргын Тамгын газраас холбогдох байгууллагудтай хамтран сумдад "Нээлттэй хаалганы өдөр" арга хэмжээг зохион байгуулан "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил"-ийн болон "Хариуцлагатай тунгалаг төр" хөтөлбөрийн нээлт хийж, байгууллага бүр үндсэн чиг үүргийн дагуу иргэдэд мэдээлэл өгч, иргэдийн санал, гомдол, эрэлт хүсэлтийг хүлээн авч, зарим төрийн үйлчилгээг газар дээр нь шуурхай хүргэхэд оршино.

Зорилт: 1. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын мэдээллийг иргэд, олон нийтэд сурталчлах

2. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлын талаарх мэдээлэл хүргэх

3. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих, иргэдэд сурталчлах

4. "Үйлдвэрлэгч –Ховд" хөтөлбөр, "Өрхийн болон жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих жилийн зорилтын талаар мэдээлэл өгөх, сурталчлах

5. Төрийн албаны тухай хууль, түүний хүрээнд батлагдсан дүрэм, журмуудыг сурталчлах, төрийн албан хаагчдад нэгдсэн ойлголт өгөх, хэрэгжилтийг ханганд ажиллах чиглэл өгөх

6. "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил", "Хариуцлагатай тунгалаг төр" хөтөлбөр, Ерөнхий сайдын өгсөн үүрэг даалгаврын хүрээнд сумдад хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил, хэрэгжилтийн явцтай танилцах, ажлыг эрчимжүүлэх

7. 2018 оноос хойш хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлыг баримтжуулах, явцад хяналт үнэлгээ хийх газар дээр нь үзэх

8. Хур системд холбох талаар зарим арга хэмжээ авах

9. Байгууллага бүр үндсэн чиг үүргийн дагуу иргэдэд тодорхой мэдээлэл өгч, иргэдийн санал, гомдол, эрэлт хүсэлтийг хүлээн авч, шаардлагатай төрийн үйлчилгээг газар дээр нь шуурхай хүргэх

Хугацаа: 2019 оны 04 дүгээр сарын 10-18-ны өдрийг дуустал  
Зохион байгуулагч: Аймгийн Засаг даргын Тамгын газар

Хамтран ажиллагч: Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Эрүүл мэндийн газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Прокурорын газар, Цагдаагийн газар, Тогтвортой амьжиргаа-3 төсөл

Хамрах хүрээ: 17 сумын Засаг даргын Тамгын газар, төсөвт албан байгууллагууд, иргэд

Сумдад ажиллах байгууллагуудын иргэдэд хүргэх үйлчилгээ:

1.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар:

-Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн чиглэлээр мэдээлэл өгч, гарын авлага тараана.

-Санал асуулга авна.

2.Эрүүл мэндийн газар:

-Эх хүүхдийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг сайжруулахад удирдлагуудын дэмжлэг

-Эх, хүүхдийн эрүүл мэнд сургалт хийнэ.

-БДЗХӨ-сэргийлэх талаар мэдээлэл, сурталчилгаа хийнэ.

-Сүрьеэ өвчинөөс сэргийлэх талаар мэдээлэл, сурталчилгаа хийнэ.

3.Нийгмийн даатгалын хэлтэс:

-Тэтгэвэр тэтгэмжийн тогтоолт олголтын талаар мэдээлэл зөвлөгөө өгнө.

-Нийгмийн даатгалын ач холбогдол, үйлчилгээ болон сайн дурын даатгал, эрүүл мэндийн даатгалын чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгч иргэдэд үйлчилгээ үзүүлнэ.

4.Улсын бүртгэлийн хэлтэс:

-Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр анхны бүртгэл, Худалдах худалдан авах гэрээ, өвийн гэрээ, бэлэглэлийн гэрээ, хамтран өмчлөгч хасах нэмэх хэлцэл, барьцаалбаргүй барьцааны гэрээ, барьцааны гэрээ дуусгавар болгох гэх мэт үйлчилгээний чиглэлээр нотлох баримтуудыг иргэдээс авчирч мэдээллийн санд бүртгэл хийнэ.

-Иргэний бүртгэлийн чиглэлээр зөрчил арилгуулах тухай өргөдөл, гомдлыг хүлээн авах, үндэсний энгийн гадад паспорт захиалах иргэдээс материал хүлээн авна.

5.Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар:

-Иргэдээс ирүүлсэн Газар эзэмших, ашиглах, өмчлөх, эрх шилжүүлэх өргөдлүүдийг хуулийн хүрээнд шийдвэрлэж, Э дугаар авч, гэрээ гэрчилгээ бичиж гардуулна.

-Засгийн газрын 182 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж Газрын төлбөр, татварыг төвлөрүүлэх, газар эзэмших гэрээг дүгнэнэ.

-“Иргэдэд ил тод, нээлттэй, ухаалаг газрын харилцаа” жилийн хүрээнд газрын кадастрын мэдээллийн санд орсон зөрүүтэй мэдээллийг арилгана.

- Хот суурин газрын төлөвлөлтын талаарх ойлголт, ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавих, зөвлөгөө өгнө.

- Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа барилга, байгууламжийн зураг төслийг ард иргэдэд сурталчилах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.

-Иргэдээс гарч байгаа санал хүсэлтийг барилга, хот байгуулалтын чиглэлийг хүлээн авч хариу өгнө.

-Барилгын түгээмэл тархацтай материалыг орцын дээж, сорьц авч лабораториор шинжлүүлнэ.

**6.Хүнс, хөдөө аж ахуйн газар:**

-Хүнс хөдөө аж ахуйн талаар 2019 онд дэвшүүлсэн зорилт, цаашид авах арга хэмжээний талаар мэдээлэл өгнө.

-Хүнс, газар тариалан, жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээний мэдээлэл гарын авлага тараана.

-Мал аж ахуйн үйлдвэрлэл технологи, мал зүйн талаарх мэдээлэл гарын авлага тараана.

**7.Мал эмнэлгийн газар:**

-Сумдын Мал эмнэлгийн тасгийн үйл ажиллагаатай танилцана.

-Мал бүхий иргэдэд малын эрүүл мэндийн тухай хуулийг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулна.

-Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх ажил, хувийн мал эмнэлгийн ажил үйлчилгээтэй танилцана.

**8.Прокурорын газар:**

-2019 оны 1 дүгээр улирлын Эрүүгийн нөхцөл байдал, тодорхой хуулийн мэдээлэл, сургалт мэдээлэл өгнө.

-Иргэдийн санал хүсэлт хүлээн авна.

**9.Цагдаагийн газар:**

-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл хийнэ.

-Иргэдийн санал хүсэлт хүлээн авна.

## АЖЛЫН ХЭСГИЙН СУМДАД АЖИЛЛАХ ХУВААРЬ

ДД	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн	Ажиллах сум	Хугацаа	
Аймгийн ИТХ-ын дарга Г.Пүрэвганди зөвшилцсөнөөр, Засаг дарга Б.Дүгэржав, Засаг даргын орлогч Т.Жаргалсайхан зарим сумдад ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллана.				
Нэгдүгээр ажлын хэсэг				
Засаг даргын Тамгын газрын дарга				
1	Д.Энхболд-Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга	Буянт	2019 оны 04 дүгээр сарын 8	
2		Мянгад	2019 оны 04 дүгээр сарын 9	
3		Дөргөн	2019 оны 04 дүгээр сарын 10	
4		Чандмань	2019 оны 04 дүгээр сарын 11	
5		Дарви	2019 оны 04 дүгээр сарын 12	
6		Зэрэг	2019 оны 04 дүгээр сарын 13	
7		Ховд	2019 оны 04 дүгээр сарын 15	
8		Эрдэнэбүрэн	2019 оны 04 дүгээр сарын 16	
Хоёрдугаар ажлын хэсэг				
Б.Ганболд-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга				
1	Б.Ганболд-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга	Булган	2019 оны 04 дүгээр сарын 8	
2		Үенч	2019 оны 04 дүгээр сарын 9	
3		Алтай	2019 оны 04 дүгээр сарын 10	
4		Цэцэг	2019 оны 04 дүгээр сарын 11	
5		Мөст	2019 оны 04 дүгээр сарын 12	
6		Мөнххайрхан	2019 оны 04 дүгээр сарын 13	
7		Манхан	2019 оны 04 дүгээр сарын 14	
8		Дуут	2019 оны 04 дүгээр сарын 15	

-оОо-